



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/001/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Н.Ариунтуяа Утас:70432545 Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.31 № 2/127
танай _____ -ны № _____ -т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Н.БАТЧУЛУУН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Өөрчлөлтгүй санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2024 оныг "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил" болгон зарлаж тайлант онд 8,640 иргэнд "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга"-ын талаарх мэдээллийг даатгуулагч, олон нийт, ажил олгогчдод таниулан сурталчлан, чиглүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Ховд аймгийн Нийгмийн даатгалын сан нь тайлант онд 1 хөтөлбөрийн 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, 89 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,654,910,259.57	13,468,432,047.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,655,935,565.28	8,678,406,099.45
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	9,655,935,565.28	8,678,406,099.45
31210	Төгрөг	9,655,935,565.28	8,678,406,099.45
31211	Төрийн сангийн харилцах	67,580,948.98	0
31213	Арилжааны банк дахь харилцах	9,588,354,616.30	8,678,406,099.45
33	АВЛАГА	4,998,974,694.29	4,790,025,948.49
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,290,960,317.55	0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,517,413,903.97	2,503,458,115.97
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0	1,966,209,959.21
33500	Бусад авлага	190,600,472.77	320,357,873.31
33510	Байгууллагаас авах авлага	190,600,472.77	77,074,826.05
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	243,283,047.26
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,654,910,259.57	13,468,432,047.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	668,626,089.61	1,578,011,170.07
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	668,626,089.61	1,578,011,170.07
41300	Өглөг	107,993,795.95	517,178,282.38
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	107,993,795.95	0
41360	Бусад өглөг	0	517,178,282.38
41361	Байгууллагад төлөх өглөг	0	63,598,897.99
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	440,611,667.29
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0	12,967,717.10
41400	Урьдчилж орсон орлого	560,632,293.66	1,060,832,887.69
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	560,632,293.66	1,060,832,887.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,986,284,169.96	11,890,420,877.87
51	Засгийн газрын хувь оролцоо	13,986,284,169.96	11,890,420,877.87
51200	Хуримтлагдсан үр дүн	13,986,284,169.96	11,890,420,877.87
51210	Өмнөх үеийн үр дүн	15,214,362,691.80	13,582,775,993.26
51220	Тайлант үеийн үр дүн	-1,228,078,521.84	-1,692,355,115.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,654,910,259.57	13,468,432,047.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	180,441,705,970.85	180,470,318,317.38
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,238,374,287.54	59,798,184,748.83
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	51,238,374,287.54	59,798,184,748.83
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,315,225,051.92	50,069,423,470.27
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,701,199,398.56	5,215,909,666.48
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,547,588,416.14	2,761,517,682.25
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	709,905,850.62	1,751,333,929.83
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,964,455,570.30	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	344,623,896.44	191,391,352.19
120	Нийтлэг татварын бус орлого	344,623,896.44	191,391,352.19
120001	Хувьцааны ногдол ашиг	0	0
120002	Хүүгийн орлого	61,725,520.50	59,918,692.73
120003	Торгуулийн орлого	0	625,500.00

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,435,910.94	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,435,910.94	0
120009	Бусад орлого	254,462,465.00	130,847,159.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	128,858,707,786.87	120,480,742,216.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,939,192,578.50	22,693,972,931.36
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,939,192,578.50	22,693,972,931.36
1330	Төсвийн захирагчдаас	117,919,515,208.37	97,786,769,285.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,919,515,208.37	97,786,769,285.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	181,669,784,492.69	182,162,673,432.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	181,669,784,492.69	182,162,673,432.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,622,950.00	16,167,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,622,950.00	16,167,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	8,903,350.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,622,950.00	7,264,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,663,161,542.69	182,146,505,932.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,732,102,037.50	123,275,427,459.63
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	95,732,102,037.50	123,275,427,459.63
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	85,931,059,505.19	58,871,078,473.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,931,059,505.19	58,871,078,473.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,228,078,521.84	-1,692,355,115.39
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,228,078,521.84	-1,692,355,115.39

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	183,232,529,502.17	192,542,746,816.17
11	ТАТВАРЫН ОРЛОГО	50,634,976,098.44	72,170,702,339.81
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	50,634,976,098.44	72,170,702,339.81
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	34,917,647,976.44	50,805,788,866.27
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,652,560,402.69	5,227,391,473.26
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,518,580,174.38	3,645,169,827.39
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	700,207,631.44	1,734,477,648.50
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,845,979,913.49	10,757,874,524.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	282,390,595.36	176,186,791.36
120	Нийтлэг татварын бус орлого	282,390,595.36	176,186,791.36
120002	Хүүгийн орлого	56,025,456.58	60,056,097.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	226,365,138.78	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	226,365,138.78	0
120009	Бусад орлого	0	116,130,693.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	132,315,162,808.37	120,195,857,685.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,395,647,600.00	22,409,088,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,395,647,600.00	22,409,088,400.00
1330	Төсвийн захирагчдаас	117,919,515,208.37	97,786,769,285.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,919,515,208.37	97,786,769,285.00

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	181,651,765,113.63	193,520,276,282.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	181,651,765,113.63	193,520,276,282.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,622,950.00	129,886,828.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,622,950.00	16,167,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	8,903,350.00
210807	Газрын төлбөр	0	0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,622,950.00	7,264,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	113,719,328.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	113,719,328.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,645,142,163.63	193,390,389,453.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,714,082,658.44	122,935,713,494.22
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	95,658,883,449.50	122,935,713,494.22
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,199,208.94	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	85,931,059,505.19	70,454,675,959.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,931,059,505.19	70,454,675,959.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,580,764,388.54	-977,529,465.83
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,580,764,388.54	-977,529,465.83
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,075,171,176.74	9,655,935,565.28
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,655,935,565.28	8,678,406,099.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	15,239,999,797.80	15,239,999,797.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-25,637,106.00	-25,637,106.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	15,214,362,691.80	15,214,362,691.80
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-1,228,078,521.84	-1,228,078,521.84
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	13,986,284,169.96	13,986,284,169.96
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	13,986,284,169.96	13,986,284,169.96
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-403,508,176.70	-403,508,176.70
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	13,582,775,993.26	13,582,775,993.26
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-1,692,355,115.39	-1,692,355,115.39

20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	11,890,420,877.87	11,890,420,877.87
----	--	---	---	-------------------	-------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	128,049,454,900.00	122,951,880,994.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	128,049,454,900.00	122,951,880,994.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,219,800.00	16,167,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,219,800.00	16,167,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,903,300.00	8,903,350.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,316,500.00	7,264,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,027,235,100.00	84,911,808,976.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,027,235,100.00	84,911,808,976.90
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	128,027,235,100.00	84,911,808,976.90
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	128,049,454,900.00	121,974,351,528.39
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,409,088,400.00	60,432,992,917.32
310001	Улсын төсвөөс санхүүжих	22,409,088,400.00	60,432,992,917.32
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,640,366,500.00	61,541,358,611.07
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	105,640,366,500.00	61,541,358,611.07
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	9,655,935,565.28
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	8,678,406,099.45

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт залруулагдаагүй 2 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 183,830,6 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд¹ алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Санхүүгийн нэгдсэн тайланг тушаах цаглабартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын системийн программын өөрчлөлтөөс шалтгаалан Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд санхүүгийн тайланг ирүүлээгүй, 2024 оны санхүүгийн тайланг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 163 дугаар албан бичгээр ирүүлсэн нь "Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлж ажиллах.

3.1.2 Авлага, өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Авлагын бүртгэлд 3-аас дээш жилийн насжилт өндөртэй 183,830.7 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь “Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөртэй авлага, өглөгийг барагдуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Нийгмийн даатгалын сан	Нийгмийн даатгалын системийн программын өөрчлөлтөөс шалтгаалан Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацаанд санхүүгийн тайланг ирүүлээгүй, 2024 оны санхүүгийн тайланг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 163 дугаар албан бичгээр ирүүлсэн.	1							1	-		
	Насжилт өндөртэй авлага барагдуулаагүй, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	183,830.7						1	183,830.7		
Нийт дүн		2	183,830.7	-	-	0	-	2	183,830.7	0	-	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	1	1			1			
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			